

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-д хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ӨВА-2021/14-14-ШТА-ГА

**Арвайхээр хот
2021 он**

**Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер Д.Гансүх,
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Шийлэгмаа,
Утас: 70323833, цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn
Аудитор: Б.Авидцэрэн,
Утас: 70323833, цахим хаяг: avidtserenb@audit.gov.mn
Аудитор: П.Норпил,
Утас: 70323833, цахим хаяг: norpilp@audit.gov.mn

**Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn**

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор (О.Батжаргал) Аудитын менежер (Д.Гансүх) Ахлах аудитор (С.Шийлэгмаа) Аудитор (Б.Авидцэрэн) (П.Норпил) 2021 оны 6 дугаар сар Уг тайланг www.audit.mn, https://www.facebook.com/uvurkhangai.audit facebook хаягаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас,70323253 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: (Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 405 тоот)	Товчилсон үгийн тайлбар2-3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй...4-12 Бүлэг А Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна. • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 29.1 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна. • Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. • Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталж байна. • Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил байна. • Зарим төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хууль, журмыг зөрчсөн байна. Бүлэг Б Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт сайжирсан байна. • Гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн ажлын чанар хангалттай хэдий ч зарим хөрөнгө оруулалтын бус ТАХ-ийн хэрэгжилтийн гэрээ хангалтгүй байна. • Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна. • Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. • Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон хэдий ч зарим санхүүжилтийг журмын дагуу олгоогүй байна. • Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна. Дүгнэлт
--	--

	Зөвлөмж Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар Хавсралтууд
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
ШТА	Шууд тайлагнах аудит
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТББ	Тендерийн баримт бичиг
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
МШУТ	Мэдээлэл шуурхай удирдлагын төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ӨВА-2021/93-ШТА-ГА кодтой төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, ХАА хууль журмын дагуу зохион байгуулагдсан эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Сант, Баянгол, Богд, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Тарагт, Уянга зэрэг сумдад, ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ зэрэг байгууллагыг хамруулан тэдгээрийн эрх зүйн үндэслэл, гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, хөрөнгө оруулалтын үр дүн, хэрэгжилтийн талаарх тайлан, судалгаа, мэдээлэлд үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS6817-5:2020 "Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS6817-7:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Барилгын тухай хууль
- ✓ Иргэний хууль
- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд
- ✓ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"

- ✓ Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- ✓ Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 33 дугаар тушаал
- ✓ Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, гүйцэтгэлийн багийн ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Авидцэрэн, П.Норпил, Р.Энхзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудитораар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга, Аймгийн ХОХБТХ, ОНӨГазар, ГХБХБГазарт 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр хүргүүллээ.

Аудитаар 350.0 сая төгрөгийн 2 албан шаардлага бичиж, 350.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 10 зөвлөмж өгөв.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/09 дүгээр тогтоолоор 2020 онд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталсан бөгөөд төсөвт тодотгол хийсэн 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар тогтоол, 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор тус тус хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулан баталсан байна.

Аймгийн 2020 оны төсөвт батлах тухай 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/09 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад Барилга байгууламжийн 3 төсөл, арга хэмжээнд 410.0 сая төгрөг, авто зам барих 1 төсөл, арга хэмжээнд 600.0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 3 төсөл, арга хэмжээнд 160.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээнд 50.0 сая төгрөг, нийт 11 төсөл, арга хэмжээнд 1,385.0 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Аймгийн 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтаас 5 төсөл, арга хэмжээний 510.0 сая төгрөгийг хасаж, мөн хөрөнгө оруулалтын жагсаалтад 10 төсөл, арга хэмжээний 619.7 сая төгрөгийг нэмж оруулж баталсан байна.

Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх тухай 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад 11 төсөл, арга хэмжээний 844.1 сая төгрөгийг нэмж баталсан байна. Нийт 3 тогтоолоор 27 төсөл, арга хэмжээний 2,338.8 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,938.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин ТИС-ийн 2 орон сууцны засварлахад төсөвлөсөн 20.0 сая төгрөг, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсвийн орон нутгийн оролцоонд зарцуулахаар төсөвлөсөн 36.0 сая төгрөг, Төгрөг сумын цэвэр усны хангамжийн зураг төсөв хийлгэхээр төсөвлөсөн 18.0 сая төгрөг, нийт 3 төсөл, арга хэмжээнд 74.0 сая төгрөгийн ажил хэрэгжээгүй тул Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ БАЙНА.

А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

А.1. Хууль, журамд заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 29.1 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2016 оны 2/01 тогтоолоор, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/09 тогтоолоор баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих хөрөнгө оруулалтад 34 төсөл, арга хэмжээнд 2 тэрбум 182 сая 041.1 мянган төгрөг баталсан байна. Үүнээс 17 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байгаа нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 29.1 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д заасныг зөрчиж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээнүүд:

Дүрслэл 1

39.8 сая төгрөг	Аймгийн МШУТ болон Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн гадна фасад засвар		50.0 сая төгрөг	Од хорооллын нийтийн орон сууцны халаалтын зуухны засвар	
15.0 сая төгрөг	Улаан загалмайн байгууллагад дэмжлэг үзүүлэх		185.8 сая төгрөг	Төрийн байгууллагуудын автомашин шинэчлэл засварт	
20.0 сая төгрөг	Спортын өндөр амжилт гаргасан тамирчдад урамшуулал олгох		5.0 сая төгрөг	Арвайхээр сумын 4 дүгээр багт ундны усны худаг худалдан авах	
70.0 сая төгрөг	Арвайхээр сумын шинээр баригдах дулааны станцын 2 дугаар ээлжийн шугам сүлжээний зураг төсөв		100.0 сая төгрөг	Арвайхээр сумын нөөцийн мах бэлтгэх зардалд	
50.0 сая төгрөг	Төрийн албан хаагчдын сургалтын төвийн өргөтгөл		100.0 сая төгрөг	Өвс бэлтгэх нөөцийн зардал	

¹ 6.6.6. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

А.1.2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.


Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус дараах төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

- Спортын өндөр амжилт гаргасан тамирчдад урамшуулал олгох 20.0 сая төгрөг,
- Гандан пунцоглин хийдийн гэгээнтний сургалтын зардалд 15.0 сая төгрөг,
- Арвайхээр сумын нөөцийн мах бэлтгэх зардалд 100.0 сая төгрөг
- Өвс бэлтгэх нөөцийн зардалд 100.0 сая төгрөг
- Улаан загалмайн байгууллагад дэмжлэг үзүүлэх 15.0 сая төгрөг

Энэ нь нийт төсөл, арга хэмжээний 13.8 хувийг эзэлж байгаа ба Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹-д заасныг мөн тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²-д заасныг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27 төсөл арга, хэмжээнд 2020 онд 2 тэрбум 338 сая 841.1 мянган төгрөг баталж, 1 тэрбум 938 сая 062.9 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнийг графикаар харуулбал:

Дүрслэл 2



¹ 4.1.24. "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг.

² 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуулийн 28.3 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дахь хэсгийн 3.2.1-д “Төсөл арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 3.2.2-т “Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах” гэж заасныг зөрчиж, хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлээгүй байна.

А.1.3. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталж байна.

Төсөл арга хэмжээг хугацаандаа бүрэн хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилтийг баталсан байна.

Хүснэгт 1

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн
1	Шинэ хороололд автозам барих	531.1
2	Төрийн албанд автомашин худалдан авах, аймаг сумдын ИТХ-ын автомашины засвар	151.4
3	Төрийн байгууллагуудын автомашины шинэчлэл, засвар, үйлчилгээ	187.2
Барилга байгууламж, өргөтгөл		
4	Аймгийн МШУТ болон Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн гадна фасад	38.5
5	Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн үлдэгдэл санхүүжилт	34.0
6	Усан спорт сургалтын төвийн цахилгаан холбоо, дохиолол, цэвэр бохир усны шугам хийх зардал	200.0
7	Гучин-ус, Уянга сумын ахмадын байрны засвар	5.9
8	Төрийн албан хаагчдын сургалтын төвийн өргөтгөл	50.0
9	Аймгийн ЗДТГ-ын зүүн өргөтгөлийн гадна засварт	79.9
10	Зүүнбаян-улаан сумын гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	30.0
11	Гучин-Ус сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын зардал	12.0
12	Бүрд сумын Бизнес хөгжлийн төвийн засвар	40.0
13	Арвайхээр суманд шинээр баригдах дулааны станцын 2 дугаар ээлжийн шугам сүлжээний зураг төсөв	70.0
14	Өвөрхангайд үйлдвэрлэв төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт	28.1
15	Арвайхээр сумын 4 дүгээр багт ундны усны худаг худалдан авах	5.0
16	Од хорооллын нийтийн орон сууцны халаалтын зуухны засвар	49.6
17	Улаан загалмайн хорооны ажлын байрны төвийн халаалтын системд холбогдсон зардлын дутуу	10.0
Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах		
18	Аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвд мэс заслын багаж, тоног төхөөрөмжийн зардал	98.6
19	Усан спорт сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж	57.1
20	Сант сумын цэцэрлэг, сургуульд тавилга, эд хогшил худалдан авах	9.6
Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээний санхүүжилт		

21	Спортын өндөр амжилт гаргасан тамирчдад урамшуулал	20.0
22	Гандан пунцоглин хийдийн гэгээнтний сургалтын зардалд	15.0
23	Арвайхээр сумын нөөцийн мах бэлтгэх зардалд	100.0
24	Өвс бэлтгэх нөөцийн зардалд	100.0
25	Улаан загалмайн байгууллагад дэмжлэг үзүүлэх	15.0
Нийт дүн		1,938.0

А.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны ихэнх нь хууль, журмын дагуу явагдсан боловч зарим алдаа, зөрчлүүд гарсан байна.

А.2.1. Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсан байна.

Тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19¹ дүгээр зүйл болон Сангийн сайдын 2013 оны 123 тушаалаар батлагдсан Тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулсан боловч дараах зөрчлүүд түгээмэл шинжтэй байна. Үүнд:

Тендерийн баримт бичиг, хэвлэлд нийтлүүлсэн тендерийн урилгын хооронд тендер нээх өдөр, цагийг зөрүүтэй зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.7², 22 дугаар зүйлийн 22.1³ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- “Усан спорт, сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж”-ийн нийлүүлэгч шалгаруулах 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн нээлт хийх хугацааг сонинд 4 дүгээр сарын 16-ны өдрөөр зар нийтэлсэн бол цахим системд 4 дүгээр сарын 1 гэж зарлажээ.
- “Өвс бэлтгэх” 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хязгаарлагдмал тендерийг 10 дугаар сарын 6-ны өдөр зарласан боловч нээлт хийх хугацааг тендерийн баримт бичигт 8 дугаар сарын 21-ний өдрөөр тусгажээ.
- “Аймгийн ЗДТГ-ын гадна засвар”-ын 40.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлэх тендерийг 6 дугаар сарын 8-ны өдөр нээхээр зарласан боловч ажил эхлэх хугацааг 5 дугаар сарын 25 гэж тендерийн баримт бичигт дурдсан байна.

А.2.2. Зарим төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хууль, журмыг зөрчсөн байна.

Ихэнх худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан боловч зарим тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, үнэлгээний дүгнэлтийг алдаатай үйлдсэн байна. Тухайлбал:

- “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд мэс заслын багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” 115.0 сая төгрөгийн өртөгтэй тендерийг үнэлэхдээ хуулийн 28 дугаар

¹ 19.2. Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

² 21.5.7. тендер нээх хугацаа.

³ 22.1. Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй.

зүйлийн 28.7.5⁴-д заасны дагуу оролцогчоос санал болгож буй тоног төхөөрөмжийн чанарын үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

- “Усан спорт, сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж”-ийн нийлүүлэгч шалгаруулах 60.0 сая төгрөгийн төсөвтэй тендерт хамгийн бага, 55.6 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Зэндмэнэ суварга ХХК-ийн тендерийг үнэлээгүй шалтгааныг хурлын тэмдэглэлд тайлбарлаагүй, 57.1 сая төгрөгийн үнэ санал болгосон Арвайкассандра ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1⁵, 28.3⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.
- Тендерийн үнэлгээний дүгнэлт, баримт материалыг албажуулахдаа хугацааны болон бичилтийн алдаа гаргах явдал түгээмэл байна. Тухайлбал: “Аймгийн ЗДТГ-ын гадна засвар”-ын 40.0 сая төгрөгийн харьцуулалтын тендерийг 6 дугаар сарын 8-ны өдөр нээж, сонгон шалгаруулах хурлыг 6 дугаар сарын 15-ны өдөр хийсэн боловч тэмдэглэлдээ 5 дугаар сарын 18-ны өдөр нээлт хийсэн гэж бичсэн, захиалагчид гэрээ байгуулах эрхийг 6 дугаар сарын 9-ний өдөр олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7⁷-д заасан мэдээллийг үнэн зөв бүрдүүлэхгүй байгааг илэрхийлж байна.

Төрийн албан хаагчдын сургалтын төвийн өргөтгөл 50.0 сая төгрөгийг зарцуулах эрхийг Аймгийн Засаг даргын захирамжаар Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Сургалт, дадлагын төвийн барилга нэртэй нээлттэй тендерийг цахимаар зарласан боловч өрсөлдөгчгүй тендер ирүүлсэн Сэлэм констракшн ХХК барилга угсралтын ажлыг гүйцэтгэжээ. Гэтэл шалгарсан компани нь тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ 6.2. (б), 6.3.(а)-д заасан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3¹ дахь заалтыг зөрчсөн байна.

“Аймаг, сумдын Засаг даргын тамгын газрын засвар”-ын 80.0 сая төгрөгийн тендерийн баримт болон “Аймгийн ЗДТГ-ын гадна засвар”-ын 40.0 сая төгрөгийн харьцуулалтын тендерт оролцогчдын ирүүлсэн цахим тендерийн материалын холбогдох ажилтан нь цар тахлын халдвар авсны улмаас шалгуулж амжаагүй тул худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан эсэхэд үнэлгээ өгөх боломжгүй байлаа.

Б. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт сайжирсан байна.

Б.1. Гүйцэтгэгч байгууллагууд ТАХ-г гэрээний дагуу хугацаанд нь хүлээлгэн өгсөн боловч зарим ажлын чанар хангалтгүй байна.

Б.1.1. Гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн ажлын чанар хангалттай хэдий ч зарим хөрөнгө оруулалтын бус ТАХ-ний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт

1. **ТАХ-ний нэр:** Шинэ хороололд авто зам барих /Арвайхээр сум/

Төсөвт өртөг: 779.9 сая төгрөг

Гүйцэтгэгч: “ӨВ-А33А” ТӨХК

⁴ 28.7.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

⁵ 28.1.Нэг үе шаттай тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хянаж, шаардлагад нийцсэн гэж үзсэн бүх тендерт үнэлгээ хийнэ.

⁶ 28.3.Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна.

⁷ 47.7.Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.

Зураг 1



Хэрэгжилт: Авто зам барих ажлын голлох суурь, газар шорооны ажил, гэрэлтүүлэг угсрах, шуудуу болон хучилтын ажил нь зохих хэмжээнд чанартай гүйцэтгэгдсэн байна. Харин ажлын тоо хэмжээнд заасны дагуу ногоон байгууламжийн ажил нь 2.6 сая төгрөгийн өртөгтэй бөгөөд байгууламжийн ажил одоо хийгдэж байна.

¹. 27.3. Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

2. **ТАХ-ний нэр:** Аймгийн ЗДТГ-ын зүүн өргөтгөлийн гадна засвар

Төсөвт өртөг: 80.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: Болор өрөг ХХК

Зураг 2



Хэрэгжилт: Зүүн өргөтгөлийн гадна фасадын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгэсэн байна

3. **ТАХ-ний нэр:** Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралт

Төсөвт өртөг: .

Гүйцэтгэгч: Бианконэро констракшн ХХК

Зураг 3



Хэрэгжилт: Өмнөх оны аудитаар тус барилгын дутуу болон чанаргүй хийгдсэн ажлуудыг дахин гүйцэтгүүлэхээр тайланд тусгасан боловч аудитын явцад зарим ажлыг дутуу хийсэн, заримыг огт гүйцэтгээгүй байна. Үүнд:

- Барилгын батлагдсан зургийн дагуу нүүр хэсэгт ойролцоогоор 16 м² талбайд саарал өнгийн цоколын плаитаг огт хийгээгүй,
- Зураг төсөвт тусгагдсан байсан гадна авто зогсоолын ажлыг огт хийгээгүй
- Гадна хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил дутуу хийгдсэн байна.

4. **ТАХ-ний нэр:** Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн автомашин

Төсөвт өртөг: 30.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Тэнчи” ХХК

Зураг 4



Хэрэгжилт: Автомашины битүүмжлэл маш муу, тоос шороо маш ихээр ордог, урд кирло нь засвартай, жолоочийн хаалганы авто мэдрэгч /чип/ ажиллахгүй байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

1. **ТАХ-ний нэр:** Өвс бэлтгэх нөөцийн зардал

Төсөвт өртөг: 100.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: Шууд гэрээ байгуулсан.

✚ Далайгүүр ХХК 35.0 сая төгрөг

✚ Отгон нинж ХХК 35.0 сая төгрөг

✚ Арвайн сүү ХХК 30.0 сая төгрөг

Хэрэгжилт: Дээрх гүйцэтгэгчдээс 7800 боодол өвс авч, өвөлжилт хүндрэлтэй сумдад хөнгөлөлттэй үнээр буюу боодол нэг бүрийг 8000 төгрөгөөр олгосон. Үнийг Аймгийн ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн ч энэ хөрөнгийг 2021 онд Аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар өвс тэжээл худалдан авах болон тээвэрлэлтийн зардалд зарцуулсан байна.

2. **ТАХ-ний нэр:** Арвайхээр сумын нөөцийн мах бэлтгэх зардал

Төсөвт өртөг: 100.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Өв.Эко Мийт” ХХК-тай шууд гэрээ байгуулсан.

Хэрэгжилт: Арвайхээр сумын ЗДТГазар нь тус компанитай нийт 17.5 тн махыг бэлтгэж, худалдаанд гарган борлуулах гэрээ хийсэн. Уг гэрээнд санхүүжилтийн 50 хувь буюу 50.0 сая төгрөгийг 2021 оны 06 сарын 10-ны дотор, үлдэгдэл 50 хувь буюу 50.0 сая төгрөгийг 2021 оны 06 сарын 30-ны дотор тус тус төвлөрүүлэхээр заасан боловч эхний эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа нь 14 хоногоор хэтэрсэн байна.

Б.1.2. Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.

Захиалагчийн хяналтыг гүйцэтгэж буй Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгөөр хийгдэж буй барилга угсралт, засварын ил далд ажлын үе шат бүрд мэргэжлийн заавар, зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн ГХБХБГазраас барилга угсралтын ажилд 4 буюу түүнээс дээш удаа, засварын ажилд 2-оос дээш удаагийн давтамжтай хяналтыг хэрэгжүүлэхдээ тогтмол 10-аас илүү тооны үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажиллажээ. Тухайн барилгын явцын хяналтыг өмнө өгсөн үүрэг даалгаврын бодит гүйцэтгэлийг бүрэн хангуулах, чанаргүй хийгдсэн ажлын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр голлон хэрэгжүүлдэг байна.

Зарим тохиолдолд барилга угсралт болон засварын ажлын гүйцэтгэл чанаргүй хийгдэх, техник хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлэх, ашиглагч байгууллагын саналыг хүлээн авахгүй байх нь гүйцэтгэгч талаас шалтгаалж байна.

Б.2. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч санхүүжилтээ бүрэн авсан тохиолдол гарсаар байна.

Б.2.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь “Барилгын тухай” хуулийн холбогдох заалтууд болон “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн холбогдох заалтууд, холбогдох яам, агентлаг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжиж байна.

Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан мэргэжилтнүүд барилга угсралтын ажлын явцад үе шатны хяналтуудыг хийж, ажлын талбай хариуцсан инженер, даамлуудад үүрэг даалгавар, заавар, зөвлөмжийг өгч, тухай бүр гэрэл зургаар баталгаажуулж, ажлын журналд тэмдэглэл үйлдэж, дараагийн үе шатны хяналт хийхдээ өмнөх үүрэг даалгаврын биелэлтийн байдал, барилгын норм, дүрэм, стандарт, барилгын чанар байдлыг хангуулан ажиллаж ирсэн нь хяналт үр дүнтэй болсон гэж үзэж байна.

Б.2.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон хэдий ч зарим санхүүжилтийг журмын дагуу олгоогүй байна.

Ажлын гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнуудаар батлуулж, гүйцэтгэлийг зураг, актаар баталгаажуулан нэхэмжлэлийг үндэслэн санхүүжилт олгож ирсэн боловч зарим төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэлд тулгуурлан олгоогүй байна. Тухайлбал:

Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2019 онд Бианконэро констракшн ХХК гүйцэтгэсний үлдэгдэл санхүүжилт 34.0 сая төгрөгийг 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас гүйцэтгэл гаргаагүй байхад олгосон зөрчил илэрлээ.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгажээ.

Б.2.3. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Гэрээний хариуцлагын хэсэгт барилга угсралт, засварын ажлыг гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хүртэлх хувиар алданги ногдуулахаар, зарим ажил гүйцэтгэх гэрээнд ашиглалтад оруулах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд үнийн дүнгийн 0.01 хувьтай тэнцэх торгуулийг хоцорсон хоног тутамд төлөхөөр заасан боловч энэ заалт хэрэгжихгүй байна.

ДҮГНЭЛТ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ БАЙНА.

А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

- **Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 29.1 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна.**
- **Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.**
- **Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталж байна.**
- **Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил байна.**
- **Зарим төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хууль, журмыг зөрчсөн байна.**

Б. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт сайжирсан байна.

- **Гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн ажлын чанар хангалттай хэдий ч зарим хөрөнгө оруулалтын бус ТАХ-ний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.**

- **Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.**
- **Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.**
- **Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон хэдий ч зарим санхүүжилтийг журмын дагуу олгоогүй байна.**
- **Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.**

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга О.Пүрэвдоржид

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг улс, орон нутгийн хөгжлийн баримт бичигтэй уялдуулах талаар анхаарч, Сангийн сайдын 2016 оны 415 тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-д заасны дагуу эрэмбэлсэн арга хэмжээг тусгаж байх.
2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлахыг таслан зогсоох.

Аймгийн Засаг дарга А.Ишдоржид:

3. Сангийн сайдын 2019 оны 282 тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагналын журам”-ын 3 дахь хэсгийн 3.2.1-д “төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 3.2.2-д “төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн, улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах” гэж заасны дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлж байх.
4. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож, холбогдох арга хэмжээ авч байх.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга 3.Балданям, ХАА-ны албаны дарга Б.Даваасүрэн нарт:

5. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулж байх
6. Тендерийн баримт бичиг, урилга, үнэлгээний дүгнэлтийг бодит байдалд нийцүүлэн хянаж нягталсны дараа албажуулж, хэрэглэгчид бодитой мэдээллийг хүргэж байх.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Гүнсэнхоролд:

7. Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж, төлөвлөлтийг сайжруулахад анхаарч ажиллах.
8. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж төлөвлөхийг таслан зогсоох.
9. Хангалтгүй хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн гэрээний биелэлтийг хангуулах арга хэмжээг авч, хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Ч.Гүнсэнхорол, СТСХ-ийн дарга Ц.Идэрсайхан нарт:

10. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 7032-3720,
E-mail: uvurkhangai_ga@yahoo.com

2021.07.07 № 595
танай 2021.07.02 -ны № 237 -Т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Танай газраас "Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д аудит хийж Бианконэро констракшн" ХХК-ийн гүйцэтгэсэн Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажилд огт гүйцэтгээгүй 3 ажил байна гэсэн дүнэлттэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Цоклын плитаны оронд барзгар шавардлага хийсэн

2. Гадна зогсоол хийх талбай нь "Хашхан" ХХК-ийн эзэмшил газар байсан тул аймгийн Засаг даргад хүсэлт өгч 2021 оны 05 сарын 31-ний өдрийн А/260 дугаар захирамжаар тус газрын газар эзэмших эрхийг хүчингүй болгон нийтийн эзэмшилд шилжүүлсэн. Газрын асуудлыг шийдвэрлүүлж гадна зогсоолыг хийх боломжтой болсон боловч орон сууцны барилга барьж байгаа компани тус талбайг цутгалтын ажлыг дуусган, кранаар хийх ажлаа гүйцэтгээд 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдөр талбайг чөлөөлж өгөхөөр харилцан тохиролцсон. Талбайг чөлөөлсөний дараа 618м.кв зогссол цутгах ажлыг гүйцэтгэгч хийнэ.

3. Гадна хүүхдийн тоглоомын бетонон талбайд резинэн дэвсгэр хийх ажлыг гүйцэтгүүлнэ.

Тус барилга нь маш бага төсвөөр зураг төсөв бүрэн гараагүй байхад баригдсан ба цэцэрлэгийн эрхлэгчийн хүсэлтийг харгалзан үзэж гадна хананд цонх нэмж гаргах, өрөөний хана тусгаарлах, аваарийн хаалганд давхар хаалга хийх, нэмэлтээр хаалга гаргах ажлуудыг гүйцэтгүүлсэн.

Дутуу байгаа ажлыг гүйцэтгүүлж тайланг хүргүүлэх болно.

ДАРГА



Т.АРИУНБОЛД

3312 00137

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

62160 Арвайхээр сум, Өвөрхангай аймаг,
УБД 1070002028, Утас/Факс: (976) 7032 2006,
E-mail: ub.umch@uvurkhangai.mn

2021.07.08 № 401

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд оруулах саналыг хүргүүлэв. Тайланд тусгаж өгнө үү.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 3.БАЛДАННЯМ



177130276

D:nuuts/alban bichig/fijig toot-A5/doc-2021

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНД ОРУУЛАХ САНАЛ

2021.07.08

Арвайхээр сум.

А.2.1. Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсан байна.

Тендерийн баримт бичгийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 19 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2013 оны 123 тушаалаар батлагдсан тендерийн баримт бичгийн дагуу боловсруулсан боловч дараах зөрчлүүд түгээмэл шинжтэй байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, хэвлэлд нийтэлсэн тендерийн урилгын хооронд тендер нээх өдөр, цагийг зөрүүтэй зарласан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.5.7¹, 22 дугаар зүйлийн 22.1² дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

–“Усан спорт, сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж”-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн нээлт хийх хугацааг сонинд 4 дүгээр сарын 16-ны өдрөөр зар нийтэлсэн бол цахим системд 4 дүгээр сарын 1 гэж зарлажээ.

Тухайн тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтыг журмаар цахим системд 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр нийтэлж, тендер шалгаруулалтын нээлтийг 4 дүгээр сарын 1-ний өдөр хийсэн болно.

–“Өвс бэлтгэх” 100,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хязгаарлагдмал тендерийг 10 дугаар сарын 06-ны өдөр зарласан боловч нээлт хийх хугацааг тендерийн баримт бичигт 08 дугаар арын 21-ний өдрөөр тусгажээ.

–“Аймгийн ЗДТГ-ын гадна засвар”-ын 40,0 сая төгрөгийн үнийн санал ирүүлэх тендерийг 6 дугаар сарын 8-ны өдөр нээхээр зарласан боловч ажил эхлэх хугацааг 5 дугаар сарын 25 гэж тендерийн баримт бичигт дурдсан байна.

Цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхад анхааран ажиллана.

2.Тендерт төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ТЭЗҮ-ийг хавсаргахгүй зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2³ дахь заалтыг зөрчсөн байна.

Энэ нь уг тендер оролцогчгүй байх, мөн шаардлага хангасан тендер ирэхгүй байх үндэслэл болсон байх талтай.

Үүнд:

–“Шинэ хорооллын авто зам барих, засвар”-ын 780.0 сая төгрөгийн өртөгтэй төслийн тендерийг эхний 2 удаад 600,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлахдаа тендерийн баримт бичгийг ТЭЗҮ, ажлын тоо хэмжээгүй нийтэлсэн бөгөөд 3 дахь удаад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

–“Стандарт хэмжил зүйн хэлтэст эталоны тоног төхөөрөмж нийлүүлэх” 11,9 сая төгрөгийн өртөгтэй үнийн санал авах тендерийг 3 удаа зарласан боловч оролцогч

оролцоогүй тул шууд худалдан авалт хийлгэсэн ба эхний 2 удаад техникийн тодорхойлолтгүй зарласан.

–“Зохиомол хээлтүүлгийн зөөврийн пунктээр ашиглах вагончик, бод малын жин” нийлүүлэх /2 дугаар багц буюу 25,0 сая төгрөг нь хээлтүүлэгч нийлүүлэх/ 36,0 сая төгрөгийн тендерийг мөн 3 удаа зарласан боловч эхний 2 удаад техникийн тодорхойлолтыг хавсаргаагүй байна.

Дээрх тендер шалгаруулалтыг зарлахдаа тухай бүр ТЭЗҮ болон ажлын тоо хэмжээг оруулж байсан бөгөөд тендер шалгаруулалт тус бүрийг дахин зарлан, www.tender.gov.mn-д хүчингүй болсон үр дүнг оруулж, цахим системд нийтлэхэд эхний зарласан тендерүүдийн ТЭЗҮ автоматаар харагдахгүй болж, хамгийн сүүлд зарласан тендерийн ТЭЗҮ идэвхижиж харагддаг. Тендер хүчингүй болох, олон дахин зарлагдах, оролцогч орохгүй байх нь захиалагчаас ирүүлсэн төсөвт өртөг хэт бага, зах зээлийн үнийн судалгаа муу хийдэг, бараа материалын үнийг төсөвт тусгахдаа инфляцтай уялдуулан тооцдоггүйгээс тухайн ажлын тоо хэмжээ төсөвт багтахгүй байдалтай холбоотой байна.

A.2.2 Зарим төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль, журмыг зөрчсөн байна.

Ихэнх худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан боловч зарим тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, үнэлгээний дүгнэлтийг алдаатай үйлдсэн байна. Тухайлбал:

“Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд мэс заслын багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” 115,0 сая төгрөгийн өртөгтэй тендерийг үнэлэхдээ хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.5¹ –д заасны дагуу оролцогчоос санал болгож буй тоног төхөөрөмжийн чанарын үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

Эрүүл мэндийн салбарын техник, тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан шалгуур, аргачлалыг тендерийн баримт бичгийн ТООЗ-д цаашид тусган, зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.

“Усан спорт сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж”-ийн нийлүүлэгч шалгаруулах 60,0 сая төгрөгийн төсөвтэй тендерт хамгийн бага 55,6 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Зэндмэнэ суварга ХХК-ийн тендерийг үнэлээгүй шалтгааныг хурлын тэмдэглэлд тайлбарлаагүй, 57.1 сая төгрөгийн үнэ санал болгосон Арвайкассандра ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1², 28.3³ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн тендерээс татгалзсан үндэслэлийг хурлын тэмдэглэлд тодорхой тусгахад анхааран ажиллана.

Тендерийн үнэлгээний дүгнэлт, баримт материалыг албажуулахдаа хугацаа болон бичилтийн алдаа гаргасан явдал түгээмэл байна. Тухайлбал: “Аймгийн ЗДТГ-ын гадна засвар”-ын 40.0 сая төгрөгийн харьцуулалтын тендерийг 6 дугаар сарын 8-ны өдөр нээж, сонгон шалгаруулалтын хурлыг 06

дугаар сарын 15-ны өдөр хийсэн боловч тэмдэглэлдээ 5 дугаар сарын 18-ны өдөр нээлт хийсэн гэж бичсэн. Захиалагчид гэрээ байгуулах эрхийг 6 дугаар сарын 9-ний өдөр олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7⁴-д заасан мэдээллийг үнэн зөв бүрдүүлэхгүй байгааг илэрхийлж байна.

Зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч цаашид зөрчил дутагдлыг залруулан ажиллана.

--oOo--

Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд өгсөн тайлбар

Байгууллагуудаас ирүүлсэн санал	Аудитын саналын тайлбар
Аймгийн ОНӨГазар: 1. Тендерт төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ТЭЗҮ-ийг хавсаргахгүй зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2³ дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь уг тендер оролцогчгүй байх, мөн шаардлага хангасан тендер ирэхгүй байх үндэслэл болсон байх талтай. Үүнд: -“Шинэ хорооллын авто зам барих, засвар”-ын 780.0 сая төгрөгийн өртөгтэй төслийн тендерийг эхний 2 удаад 600,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлахдаа тендерийн баримт бичгийг ТЭЗҮ, ажлын тоо хэмжээгүй нийтэлсэн бөгөөд 3 дахь удаад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. -“Стандарт хэмжил зүйн хэлтэст эталоны тоног төхөөрөмж нийлүүлэх” 11,9 сая төгрөгийн өртөгтэй үнийн санал авах тендерийг 3 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй тул шууд худалдан авалт хийлгэсэн ба эхний 2 удаад техникийн тодорхойлолтгүй зарласан. -“Зохиомол хээлтүүлгийн зөөврийн пунктээр ашиглах вагончик, бод малын жин” нийлүүлэх /2 дугаар багц буюу 25,0 сая төгрөг нь хээлтүүлэгч нийлүүлэх/ 36,0 сая төгрөгийн тендерийг мөн 3 удаа зарласан боловч эхний 2 удаад техникийн тодорхойлолтыг хавсаргаагүй байна. Дээрх тендер шалгаруулалтыг зарлахдаа тухай бүр ТЭЗҮ болон ажлын тоо хэмжээг оруулж байсан бөгөөд тендер шалгаруулалт тус бүрийг дахин зарлан, <u>Алллл/Лепс1ег.доу.тп</u>-д хүчингүй болсон үр дүнг оруулж, цахим системд нийтлэхэд эхний зарласан тендерүүдийн ТЭЗҮ автоматаар харагдахгүй болж, хамгийн сүүлд зарласан тендерийн ТЭЗҮ идэвхижиж харагддаг. Тендер хүчингүй болох, олон дахин зарлагдах, оролцогч орохгүй байх нь захиалагчаас ирүүлсэн төсөвт өртөг хэт бага, зах зээлийн үнийн судалгаа муу хийдэг, бараа материалын үнийг төсөвт тусгахдаа инфляцтай уялдуулан тооцдоггүйгээс тухайн ажлын тоо хэмжээ төсөвт багтахгүй байдалтай холбоотой байна.	1. А.2.1 дэх хэсгийн 2-т: “Тендерт төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ТЭЗҮ-ийг хавсаргахгүй зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг зөрчсөн байна” гэж бичсэн хэсгийг жишээ баримтын хамт аудитын тайлангаас хассан болно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР